

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/020/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим сайт: www.audit.mn

2025.03.21 № 01/236
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА Л.АМГАЛАНБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Заамар сумын төвөөс Баянхангай сум хүртэлх хатуу хучилттай замын ажлыг 15,008,101.1 мянган төгрөгөөр, 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг 1,961,645.8 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хайлааст багт хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн 584,904.4 мянган төгрөгөөр, төрийн албан хаагчдын орон сууц 377,000.0 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл 656,013.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сумын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 8 хөтөлбөр, 155 арга хэмжээг хэрэгжүүлж 98,0 хувьтай дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 58,2 хувь байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

412505390

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,121,997.0	3,763,755.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,345,050.8	2,995,861.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	419,747.3	366,402.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	357,198.9	401,491.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		7,912,885.2	8,804,042.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	7,912,885.2	8,804,042.7
39200	Биет хөрөнгө		7,174,705.4	8,039,013.1
39300	Биет бус хөрөнгө	13	738,179.8	765,029.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		10,034,882.3	12,567,797.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		328,604.6	249,251.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	328,604.6	249,251.1
41300	Өглөг	17а, 17б	328,604.6	249,251.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		9,706,277.7	12,318,546.7
51	Засгийн газрын хувь оролцоо		9,706,277.7	12,318,546.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,257,283.2	2,257,283.2
51200	Хуримтлагдсан үр дүн		7,039,835.1	9,652,104.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		409,159.4	409,159.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		10,034,882.3	12,567,797.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		12,811,947.2	7,572,541.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		3,676,911.6	4,687,894.3
110	Орлогын албан татвар		3,103,297.4	4,244,172.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		3,127,297.4	4,244,172.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-24,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		175,448.4	113,467.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		398,165.8	330,254.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,894,311.1	531,742.9
120	Нийтлэг татварын бус орлого		3,844,311.1	526,742.9
122	Тусламжийн орлого		50,000.0	5,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,240,724.6	2,352,904.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	8,602,241.4	4,664,309.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,647,204.0	4,158,938.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,123,318.5	2,868,187.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		543,677.8	854,483.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		69,066.0	107,241.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		100,344.2	774,153.4
2104	Хангамж, бараа материалын зардал		123,816.8	104,326.3
2105	Нормативт зардал		0.0	659.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,800.0	50,616.6
2107	Томилолт, зочны зардал		11,088.0	14,161.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,039.0	10,905.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,258,486.7	951,639.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,523,885.4	1,290,751.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		955,037.4	505,370.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,209,705.8	2,908,232.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,581,258.4	295,963.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,628,447.4	2,612,269.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,077,830.3	7,077,830.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,077,830.3	7,077,830.3
9	Тайлант үеийн үр дүн	2,628,447.4	2,628,447.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,706,277.7	9,706,277.7
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,706,277.7	9,706,277.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,706,277.7	9,706,277.7
19	Тайлант үеийн үр дүн	2,612,269.0	2,612,269.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,318,546.7	12,318,546.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,368,292.9	7,401,746.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,676,911.6	4,687,894.3
110	Орлогын албан татвар	3,103,297.4	4,244,172.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,127,297.4	4,244,172.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-24,000.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	175,448.4	113,467.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	398,165.8	330,254.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,098.3	22,181.8
1181	Газрын төлбөр	373,067.4	308,072.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	405,549.3	326,670.5
120	Нийтлэг татварын бус орлого	355,549.3	321,670.5
122	Тусламжийн орлого	50,000.0	5,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,285,832.0	2,387,181.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,341,376.9	3,726,276.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,341,376.9	3,726,276.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,785,007.3	2,434,644.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,787.7	863,640.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,066.0	107,241.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,666.4	925,308.5
2104	Хангамж, бараа материалын зардал	129,125.3	114,653.4
2105	Нормативт зардал	93,160.5	113,462.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300.0	65,669.8
2107	Томилолт, зочны зардал	11,088.0	14,161.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,365.1	13,075.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	798,448.2	217,431.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,556,369.7	1,291,632.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,026,915.9	3,675,469.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,705,451.8	2,024,609.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,705,451.8	2,024,609.6
2200	Дотоод эх үүсвэрээр	2,705,451.8	2,024,609.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,705,451.8	-2,024,609.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-194,100.0	-50.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	194,100.0	50.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-872,635.8	1,650,810.2
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,217,686.6	1,345,050.8
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,345,050.8	2,995,861.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,610,521.7	3,849,244.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,304,034.8	2,136,809.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,272,526.8	2,111,355.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,132.6	766,654.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,516.6	96,264.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,058,314.9	925,182.8
2104	Хангамж, бараа материалын зардал	107,539.8	106,727.3
2105	Нормативт зардал	370.5	370.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,590.0	66,169.8
2107	Томилолт, зочны зардал	17,443.0	11,962.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,878.0	10,972.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,741.4	127,052.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,508.0	25,453.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,508.0	25,453.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,244,486.9	1,712,385.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	62,000.0	50.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,610,521.7	6,012,918.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,942,792.2	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,532,316.5	5,923,620.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,076,162.0	84,297.8
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	59,251.0	5,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	458,687.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,117,878.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	66	66
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32	32

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	405,773.8	486,662.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	176,549.2	177,437.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,181.8	144,853.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,900.4	87,763.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,487.6	10,976.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,122.9	7,586.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.0	2,500.0
2107	Томилолт, зочны зардал	-	2,199.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,507.7	2,103.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,163.3	31,723.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,367.4	32,584.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	32,533.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,367.4	50.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	229,224.6	309,224.6
2200	Дотоод эх үүсвэрээр	229,224.6	309,224.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	405,773.8	489,277.2

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,665.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Нийт алдаа, зөрчлөөс 975,119.2 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус, урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 88,216.8 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 975,119.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 975,119.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Заамарын хөгжил ОНӨТҮГ	1					1		
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1	1		

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	2,665.6			1	2,665.6	1	2,665.6		
Засаг даргын Тамгын газар	1	377,314.7			1	377,314.7	1	377,314.7		
ЭЭС	1	766.2			1	766.2	1	766.2		
ХХС	1	150.0			1	150.0	1	150.0		
Дүн	4	380,896.5	0	0	4	380,896.5	4	380,896.5		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	975,119.2					1	975,119.2
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	2,201.8	2	2,201.8				
Засаг даргын Тамгын газар	6	63,300.4	2	3,469.5	3	59,830.9	1	-
Цэцэрлэг	1	4,083.5	0	0.0	0	-	1	4,083.5
Шижир алтны цэцэрлэг	2	26,607.2	1	554.7	1	26,052.4	0	-
Эмийн эргэлтийн сан	3	6,152.8			2	6,152.8	1	
Заамар хөгжил ОНӨААТҮГ	1	9,222.8			1	9,222.8	1	
Дүн	17	1,086,687.7	5	6,226.0	7	101,258.9	5	979,202.7